



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 6/54

Чингис хот

Ц.Мөнгөнзүлэг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батноров сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийгмийн бодлогын хэлтсийн Соёлын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнгөнзүлэг Батноров сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд шилжүүлэн ажиллуулах болсон тул 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Соёлын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн томилогдох хүртэл албан үүргийг түр орлон гүйцэтгэж ажиллахыг Боловсролын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Өнөрцэцэгт үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвахатан Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Ж.Цэнджав Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, нийгмийн даатгал, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Т.Баямбадулам Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Аж ахуйн нярав

4. Ц.Мөнгөнзүлтай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

